

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2025 оны 01 дүгээр сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ-ий өсөлт

(2024 он)

4.9 хувь

Гадаад валютын нөөц

(2025 оны 1 дүгээр сар)

4,884 сая \$

Инфляц

(2025 оны 1 дүгээр сар)

9.6 хувь

Төсвийн тэнцэл

(2025 оны 1 дүгээр сар)

-493 тэрбум ₮

Экспорт

(2024 оны 1 дүгээр сар)

1,324 сая \$

Импорт

(2025 оны 1 дүгээр сар)

973 сая \$

ГШХО

(2024 оны эхний 3 улирал)

2,900 сая \$

Зээлийн хүү

(2025 оны 1 дүгээр сар)

16.9 хувь

Ажилчдын тоо

(2024 оны 4 дүгээр улирал)

1.35 сая

\*1V улирлын байдлаар ажиллах хүчний орлогооны түвшин 62.2 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2024 оны 3 дугаар улирал)

16.3 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2024 оны эцэс)

108.4 мянга

\*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2024 оны 4 дүгээр улирал)


5.9 хувь



Монгол Улсын эдийн засаг 2024 онд 4.9 хувиар өсөж, нэрлэсэн ДНБ 80 их наяд төгрөгт, нэг хүнд ногдох ДНБ 6,890 ам.долларт хүрлээ. Худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил болон татварын орлого сайн байсан нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Харин хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын уналт өсөлтийг хязгаарлав.

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(бодит ДНБ-ий хуримтлагдан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(2024 он)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## УУЛУУРХАЙ


(бодит ДНБ-ий хуримтлагдан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

■ Бодит ДНБ 2024 онд **4.9 хувиар өслөө.**

■ Анхдагч салбар: Уул уурхайн салбар 10.8 хувиар тэлж, өсөлтийн 1.4 хувийг бүрдүүлсэн бол ХАА-н салбар 28.7 хувиар агшиж нийт өсөлтийг -3.6 нэгж хувиар хязгаарлалаа.

■ Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 2.5 хувиар өсөж өсөлтийн 0.3 нэгж хувийг;

■ Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 9.8 хувиар өсөж өсөлтийн 4.8 хувийг;

■ Бүтээгдэхүүний цэвэр татвар 16.1 хувиар өсөж өсөлтийн 2.0 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.

■ 2024 онд худалдааны үйлчилгээний салбарын идэвх сайн байж, татварын орлого нэмэгдэн, эдийн засгийн өсөлтийг голлон дэмжив.

■ Харин том малын зүй бус хорогдол оны эхнээс нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбар уналттай байв.

■ Уул уурхайн салбар 2024 онд 10.8 хувиар өсөв.

■ Нүүрс олборлолт 100.1 сая тоннд хүрч, өмнөх оноос 23 хувиар өссөн нь гол нөлөөллөө.

■ Мөн зэсийн баяжмалын үйлдвэрлэл 12 хувиар, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалын олборлолт 32 хувиар нэмэгдсэн байна.

■ Харин алт болон газрын тосны олборлолт тус тус 15 болон 14 хувиар буурч, тус салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлөв.

■ ХАА-н салбар 2024 онд улиралд 28.7 хувиар агшлаа.

■ Том малын зүй бус хорогдол 9.4 сая толгойд хүрч өмнөх оноос 4.4 сая толгой малаар нэмэгдсэн байна. Энэ нь 2024 оны эхэнд тоологдсон нийт малын 14.5 хувьд хүрч, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл жил дараалан буурлаа.


■ Нийт малын тоо 57.6 сая толгой болж, 2015 онтой ойролцоо түвшинд хүрлээ.

■ Нийт тариалсан талбай өнгөрсөн оноос 1.5 хувиар, хураасан улаан буудай 5.4 хувиар тус тус буурлаа.




Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 онд 5.0 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжсэн бол хэрэглээ, хөрөнгө оруулалтын идэвхжилийг даган бараа, үйлчилгээний импорт нэмэгдсэн нь өсөлтийг сааруулав.

### ДНБ ӨСӨЛТИЙН БҮТЭЦ (жилийн өсөлтийн хувь)




- Эдийн засгийн өсөлтөд дотоод эрэлт голлон нөлөөлөв. Нийт өсөлтийн 8.6 нэгж хувийг өрхүүдийн хэрэглээ, 3.6 нэгж хувийг засгийн газрын хэрэглээ, 6.2 нэгж хувийг хөрөнгө оруулалт бүрдүүлсэн байна.
- Харин импортын эрчимтэй өсөлт цэвэр экспортыг бууруулж, өсөлтөд сөргөөр нөлөөллөө.

### ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ (жилийн өсөлтийн хувь)




- Төрийн хэрэглээний өсөлт 2024 оны сүүлийн хагаст саарч, жилийн дүнгээр 18.3 хувьд хүрэв.
- Цалин, тэтгэвэр, тэтгэмж өсөөний зэрэгцээ хэрэглээний зээл олголт нэмэгдсэн нь 2024 онд өрхийн хэрэглээг дэмжиж, өрхийн хэрэглээ урьдчилсан гүйцэтгэлээр 12.9 хувиар өссөн байна.

### ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН БҮТЭЦ (жилийн өсөлтийн хувь)



- Үндсэн хөрөнгийн хуримтлал 19.7 хувиар өсөхөд уул уурхайн хүнд машин механизм болон авто зам зэрэг инженерийн барилга байгууламжийн бүтээн байгуулалт өссөн нь голлон нөлөөллөө.

### ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ (жилийн өсөлтийн хувь)




- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 0.7 хувиар өссөн бол хэрэглээ, хөрөнгө оруулалт идэвхэжсэнээр бараа, үйлчилгээний импорт 17.7 хувиар өслөө.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны 1 дүгээр сард 6.6 хувиар өсөв. Нүүрс, төмрийн хүдэр, алт, газрын тос зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, мах, гурил, ундаа, арьс шир, самнасан ноолуурын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс бууралттай байна.


## НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(тэрбум төгрөг)



## НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(тэрбум төгрөг, ҮҮИ-ээр засварласан бодит дүн)




## УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

(голлех бүтээгдэхүүнээр)

Төрөл	Өмнөх оны мөн үеэс өөрчлөлт:
Нүүрс	6.6 сая тонн -6%
Зэсийн баяжмал	147 мян. тонн 24%
Газрын тос	0.3 сая баррель -9%
Алт	0.6 тонн -17%
Төмрийн хүдэр	0.3 сая тонн -1%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2025 оны 1 дүгээр сард 2.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өслөө.
- Зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 8.1 хувиар нэмэгдлээ.
- Харин боловсруулах салбарын үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэрлэсэн дүнгээр 6.5 хувиар буурав.

- Бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) 2025 оны 1 дүгээр сард 5.2 хувиар буурлаа.
- Боловсруулах үйлдвэрлэлийн 65 орчим хувьтай тэнцэх үйлдвэрлэл 2025 оны 1 дүгээр сарын байдлаар өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. /Тухайлбал, мах 37 хувь (2.4 мянган тонн), гурил 13 хувь (2.9 мянган тонн), ундаа 17 хувь (8.5 сая литр), самнасан ноолуур 25 хувь (15 тонн), ган төмөр хийц 98 хувиар (481 тонн) тус тус буурсан байна./

- Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр 2025 оны 1 дүгээр сард нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 24 хувиар өслөө.
- Харин нүүрс олборлолт 2025 оны 1 дүгээр сард 6.6 сая тоннд хүрч, өмнөх оноос 6 хувиар буурав.
- Мөн төмрийн хүдэр, баяжмалын олборлолт бага зэрэг буурч, алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс доогуур байна.

- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2025 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар, цар тахлын өмнөх үеэс 76.5 хувиар тус тус өслөө.

### Үнэ өссөн:





- Уул уурхай, олборлолт 23.4 хувиар;
- Хүнсний бүтээгдэхүүн 7.8 хувиар;
- Ундаа үйлдвэрлэл 10.1 хувиар;
- Резинэн, хуванцар үйлдвэрлэл 42.8 хувиар;
- Тавилгаас бусад мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл 88.2 хувиар тус тус өссөн бол

### Үнэ буурсан:

- Уул уурхай, олборлолтын туслах бусад үйл ажиллагаа 10.1 хувиар буурсан байна.



Боловсруулах салбарын үйлдвэрлэл 2025 оны 1 дүгээр сард үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүнгээр 12.3 хувиар буурлаа. Боловсруулах салбарын 65 орчим хувийг бүрдүүлдэг мах, гурил, сүү, арьс шир, ноолуур, бүх төрлийн ундааны үйлдвэрлэл болон металл боловсруулах үйлдвэрлэл буурсан байна.



- Боловсруулсан малын мах 2025 оны 1 дүгээр сард 4.2 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 37 хувиар буурлаа.
- Махны биет хэмжээний бууралтын нөлөөгөөр боловсруулах салбарын 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 22.2 хувиар буураад байна.



- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны 1 дүгээр сард 18.8 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 13 хувиар буурлаа.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ буурсан голлох нөлөөгөөр боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг үр тарианы гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 24.2 хувиар буурлаа.

- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны 1 дүгээр сард 40.2 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 17 хувиар буурлаа.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ буурснаар боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 35.1 хувиар буурлаа.

- Ноолууран сүлжмэл эдлэлийн биет хэмжээ 2025 оны 1 дүгээр сард 26 мянган ширхэг болж, өмнөх оны мөн үеэс 26 хувиар буурлаа.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээ буурсан 4 боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг нэхмэлийн бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) ӨМНӨХ ОНООС 10.9 хувиар өссөн байна.



Үйлчилгээний салбарт худалдаа, зочид буудал, нийтийн хоол зэрэг салбаруудын идэвх сайн байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын нөлөөгөөр тээврийн салбарын ачаа тээвэр өсөлттэй байна.




### ТЭЭВЭР

(тээсэн ачаа, сая тонн)

	2024.01	2025.01	ӨМНӨХ ОНООС
Төмөр зам	3.6	3.8	4%
Уул уурхайн бүт.	2.6	2.7	4%
Агаар	0.001	0.001	-18%
	2023.12	2024.12	
Авто зам	69.9	85.2	22%
Уул уурхайн бүт.	66.9	81.9	22%

Тэмдэглэл: Авто замын тээврийн статистик нь улирлаар зарлагдадаг.  
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар эзэлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2024 онд нэрлэсэн дүнгээр 68 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 13.4 хувиар өссөн байна. Харин үнийн нөлөөг засварласан бодит орлогын дүн 6.8 хувиар өсөлттэй байв.
- Өсөлтөд хүнсний бүтээгдэхүүн болон моторт тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийн худалдаа зэрэг хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

- Зочид буудал болон нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 2024 онд нэрлэсэн дүнгээр 12.8 болон 13.8 хувиар тус тус өссөн байна.
- Харин үнийн нөлөөг засварласан бодит орлогын дүн 2024 онд 3.5 болон 4.6 хувийн өсөлттэй байна.


- Төмөр замаар 2025 оны 1 дүгээр сард 3.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 хувиар өссөн үзүүлэлт байна. Үүний 73 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 18 хувиар буурсан байна.
- Авто замаар 2024 онд 85.2 сая тонн ачаа тээвэрлэсний 81.9 сая тонн буюу 96 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.

- 2025 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 1 хувиар бага 30.1 мянган жуулчид Монгол Улсын хилээр орсон байна.



2025 оны 1 дүгээр сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 2.0 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 46 сая ам.долларын ашигтай гарлаа.


## ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 2025 оны 1 дүгээр сард 1,019 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 23 хувиар буурлаа.
- Нийт экспортын 94 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 54 хувийг бүрдүүлж байна.


## ГОЛЛОХ БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспортын орлого 449 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 45 хувиар буурлаа.
- Зэсийн баяжмалын экспортын орлого 264 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 20 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 71 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3 дахин өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 42 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 12 хувиар буурлаа.


## ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2025 оны 1 дүгээр сарын байдлаар импорт 973 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 4 хувиар өссөн байна.
- Нийт импортын 19 хувийг тоног төхөөрөмж, 20 хувийг нефть, 14 хувийг суудлын автомашин эзэлж байна.

## ГОЛЛОХ БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Тоног төхөөрөмжийн импорт 181 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 20 хувиар өслөө.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 194 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 138 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16 хувиар өслөө.






2025 оны 1 дүгээр сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 94 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 88 хувийг бүрдүүллээ.

### НҮҮРС


(саятонн)



- Нүүрсний экспорт 2025 оны 1 дүгээр сард 5.8 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 14 хувиар буурлаа.

### ЗЭСИЙН БАЯМЖАЛ


(мян тонн)



- Зэсийн баяжмалын экспорт 2025 оны 1 дүгээр сард 135 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар өслөө.

### ТӨМРИЙН ХҮДЭР


(мян тонн)



- Төмрийн хүдрийн экспорт 2025 оны 1 дүгээр сард 281 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 20 буурлаа.

### ГАЗРЫН ТОС

(мян баррель)




- Газрын тосны экспорт 2025 оны 1 дүгээр сард 561 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 33 хувиар буурлаа.



2025 оны 1 дүгээр сард голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.


### МАЛЫН МАХ (сая ам.доллар)



Эх сурвалж Гаалийн ерөнхий газар

- Малын махны экспорт 2025 оны 1 дүгээр сард 17 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 37 хувиар буурлаа.
- Тэр дундаа боловсруулсан махны экспорт өмнөх оны мөн үеэс 3 дахин багассан байна.


### АРЬС ШИР (сая ам.доллар)



Эх сурвалж Гаалийн ерөнхий газар

- Боловсруулсан арьс ширний экспорт 2025 оны 1 дүгээр сард 10 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 84 хувиар буурлаа.


### НООЛУУР (сая ам.доллар)



Эх сурвалж Гаалийн ерөнхий газар

- Ноолуурын экспорт 2025 оны 1 дүгээр сард 34 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 51 хувиар буурлаа.

### НООС (сая ам.доллар)



Эх сурвалж Гаалийн ерөнхий газар


- Ноосны экспорт 2025 оны 1 дүгээр сард 135 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 84 хувиар буурлаа.



### ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

#### НҮҮРС


(\$/тонн, Сингапурын бирждэж Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

#### ЗЭС


(\$/тонн, Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

#### ТӨМРИЙН БАЯЖМАЛ


(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

#### ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Брент)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2025 оны 1 дүгээр сарын дундаж үнэ 194 ам.долларт хүрч, өмнөх сараас 3 хувиар, өмнөх оны мөн үеэс 41 хувиар буурсан байна.

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2025 оны 1 дүгээр сарын дундажар 8,981 ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 7 хувиар өссөн байна.


- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2025 оны 1 дүгээр дундаж үнэ 100 ам.долларт хүрч, өмнөх сараас 4 хувиар, өмнөх оны мөн үеэс 25 хувиар буурсан байна.

- Брент газрын тосны 2025 оны 1 дугаар сарын дундаж үнэ 78 ам.долларт хүрч, өмнөх сараас 7 хувиар буурсан хэдий ч өмнөх оны мөн үеэс 4 хувиар өслөө.




Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний 1 сард 25.6 мянган тонн нүүрс, 1.0 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал арилжаалаад байна.

### НҮҮРСНИЙ АРИЛЖАА (сая тонн)




- 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 2023 оноос хойш нийт 37.6 сая тонн нүүрс арилжиж, 4.6 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 онд сард 22.4 сая тонн нүүрс арилжиж, 2.4 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны 1 дүгээр сард 0.3 сая тонн нүүрс борлууллаа.

### НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ (ам.доллар/тонн)




- 2025 оны 1 дүгээр сард нүүрсний дуудах дундаж үнэ 72 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 72 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 1 дүгээр сард хэлцлийн доод үнэ 49 ам.доллар, дээд үнэ 122 ам.долларт хүрэв.

### ТӨМРИЙН АРИЛЖАА (мянган тонн)



- 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 4.1 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 284 сая ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 онд 2.4 сая тонн төмрийг арилжаалж, 167 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны 1 дүгээр сард 1.0 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.

### ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ (ам.доллар/тонн)




- Төмрийн хүдэр болон баяжмалын 1 дүгээр сарын дуудах дундаж үнэ 61 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 62 ам.доллар болж өсөв.
- Төмрийн төрлөөс хамааран 1 дүгээр сард хэлцлийн доод үнэ 55 ам.доллар, дээд үнэ 86 ам.долларт хүрэв.




Төлбөрийн тэнцэл 2024 онд 622 сая ам.долларын ашигтай гарсан бол гадаад валютын улсын нөөц 2025 оны 1 дүгээр сарын эцэст 4,884 сая ам.доллар болж, өмнөх сараас 11.4 хувиар буурлаа.

### ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ (сая ам.доллар)




Тэмдэглэл: Төлбөрийн тэнцлийн статистик 1 сарын хоцрогдолтой зарлагддаг.  
Эх сурвалж: Монголбанк

### ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ (сая ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк

### ХАНШИЙН ӨДРИЙН ӨӨРЧЛӨЛТ (төгрөг/ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

### ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

- Төлбөрийн тэнцэл 2024 оны эцэст 622 сая ам.долларын ашигтай гарлаа.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 0.8 тэрбум ам.доллороор нэмэгдсэн ч импортын өсөлт 2.9 тэрбум ам.долларт хүрснээр урсгал данс алдагдалтай гарлаа.
- Төлбөрийн тэнцлийн шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал\* 2024 онд 2.6 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 0.4 тэрбум ам.доллороор өссөн байна.
- Гадаад валютын улсын нөөц 2025 оны 1 дүгээр сарын эцэст 4,884 сая ам.доллар болж, өмнөх оны эцсээс 626 сая ам.доллороор буюу 11.4 хувиар буурлаа.
- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 1 дүгээр сард өдөрт дунджаар 1.3 төгрөгөөр суларч, сарын эцсийн ханш 3,448 төгрөгт хүрлээ.
- Төв банк 2025 оны 1 дүгээр сард 1 удаагийн дуудлага худалдаагаар дунджаар 86 сая ам.долларыг, нийт 777 сая ам.долларыг зах зээлд нийлүүлээ.
- Энэ нь өмнөх оны мөн үеэс 44 хувиар буюу 238 сая ам.доллороор өссөн дүн байна.


\*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй халбоотой гарах урсгалыг хассан дүн



Инфляц 2025 оны 1 дүгээр сард 9.6 хувьд хүрч, өмнөх сараас 0.6 нэгж хувиар эрчимжлээ. Инфляц өмнөх сараас эрчимжихэд мах, нийтийн хоолны үйлчилгээ, гэр ахуйн бараа, эрүүл мэндийн даатгал, үсчин гоо сайхны үйлчилгээний үнийн өсөлт голлон нөлөөлжээ. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад 1.4 хувиар өссөн байна.

## ЖИЛИЙН ИНФЛЯЦ

(хувь)




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Инфляц 2025 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 9.6 хувьд гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.7 нэгж хувь (27.8 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 6.9 нэгж хувь буюу 72.2 хувийг эзэлж байна.

## САРЫН ИНФЛЯЦ

(хувь)




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- 2025 оны 1 дүгээр сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.4 хувиар өсөв.
- Үүнд хүнсний бараа 2.3 хувиар, нийтийн хоолны үйлчилгээ 4.8 хувиар, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний үнэ 100 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

## СУУРЬ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2025 оны 1 дүгээр сард суурь инфляц 8.5 хувь гарч, нийт инфляцын 5.6 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 7 сар өссөн үзүүлэлттэй байна.

## ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

(хувь)




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2025 оны 1 дүгээр сард жилийн инфляцын 23.7 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар өслөө.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 23.3 хувиар өслөө.




Олон улсад чингэлэг тээврийн үнэ өндөр хэвээр байгаа нь импортын инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна. Хүнсний үнийн индекс 2025 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### ХҮНСНИЙ БА ХҮНСНИЙ БУС ИНФЛЯЦ




- Хүнсний инфляц 2025 оны 1 дүгээр сард 9.4 хувь болж, нийт инфляцын 2.7 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц өмнөх сараас 0.2 нэгж хувиар эрчимжихэд мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт голлох нөлөө үзүүллээ.
- Хүнсний бус инфляц 9.2 хувь болж, нийт инфляцын 6.9 нэгж хувийг бүрдүүллээ. Хүнсний бус инфляц өмнөх сараас 0.4 нэгж хувиар өсөхөд гэр ахуйн бараа болон зарим үйлчилгээний үнэ өссөн нь нөлөөлөв.

### ИМПОРТЫН ИНФЛЯЦ БА ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ



- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 1 дүгээр сард дунджаар 3,432 төгрөг болж, өмнөх сараас 0.4 хувиар сулрав.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ өмнөх сараас 0.5 хувиар өссөн байна.

### ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ҮНЭ



- Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис/Суэцийн сувагт үүсээд буй халдлагаас үүдэлтэйгээр өсөөд байна.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 40 фут конгейнер тутамд 3,095 ам.доллар буюу өмнөх оны мөн үеэс 17 хувиар буурсан байна. Энэ нь цар тахлаас өмнөх 2019 оны дундаж үеэс 118 хувиар өндөр үзүүлэлт юм.
- Чингэлэг тээврийн үнэ өндөр хэвээр байгаа нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.

### ХҮНСНИЙ ҮНИЙН ИНДЕКС




- НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2025 оны 1 дүгээр сард 124.9 болж, өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өссөн бол, өмнөх сараас 1.6 хувиар буурсан байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр элсэн чихэр, ургамлын тос, махны үнэ буурсан бол сүүн бүтээгдэхүүн, үр тарианы үнэ өсжээ.



Монгол Улсын нэгдсэн төсөв 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 493 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсөв алдагдалтай гарахад төсвийн орлогын бууралт голлон нөлөөллөө.

**ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ**


(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

**ТӨСВИЙН ОРЛОГО**


(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

**ТӨСВИЙН ЗАРЛАГА**


(зарлагын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

**ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)**

(Эүүн тэнцлэг: их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Сангийн яам

- Нэгдсэн төсөв 2025 оны 1 дүгээр сард 493 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, төсвийн тэнцэл өмнөх оноос 1.2 их наяд төгрөгөөр буурлаа.

- Орлого 1.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 их наяд төгрөг буюу 36.7 хувиар буурсан байна.
- Дээрх бууралтад орлогын албан татвар 358 тэрбум төгрөг буюу 46.6 хувиар, НӨАТ 152 тэрбум төгрөг буюу 33.9 хувиар, АМНАТ-ийн орлого 606 тэрбум төгрөгөөр буюу 7 дахин буурсан нь голлон нөлөөлөөд байна.

- Зарлага 2025 оны 1 дүгээр сард 2.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 106 тэрбум төгрөг буюу 5.2 хувиар нэмэгдсэн байна.
- 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинд уялдуулан 6 хувиар нэмэхээр 2025 оны Төсвийн тухай хуульд тусгасан.
- Үүнтэй холбогдуулан цалингийн зардал өмнөх оны мөн үеэс 125 тэрбум төгрөг буюу 35.9 хувиар, тэтгэвэр тэтгэмжийн зардал 117 тэрбум төгрөг буюу 31.6 хувиар тус тус өссөн байна.


- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2024 оны эцэст 33.4 их наяд төгрөгт хүрч, ДНБ-д эзлэх хувь 42.2 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.






Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 1 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар өсөж, 41.9 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 1 дүгээр сард 37.1 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 35.0 хувьд хүрлээ.

## МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж Монголбанк

## ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж Монголбанк

## ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (хувь)



Эх сурвалж Монголбанк

## ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)



Эх сурвалж Монголбанк

- Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 1 дүгээр сарын эцэст 41.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 11.8 хувиар өссөн байна.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 12.3 нэгж хувь, төгрөгийн харилцах 5.7 нэгж хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.1 нэгж хувь, гадаад валютын харилцах -5.9 нэгж хувь, гадаад валютын хадгаламж -0.3 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.



- Нийт хадгаламж 26.5 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 21.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 26.8 хувиар өссөн бол өмнөх сараас 1.9 хувиар буурлаа.
- Гадаад валютын хадгаламж 4.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар, өмнөх сараас 0.4 хувиар буурлаа.

- Банкнүүдэн зээлийн үлдэгдэл 2025 оны 1 дүгээр сарын эцэст 37.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 35.0 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувиар буурсан байна.

- Банкнүүдэн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 1 дүгээр сард 16.9 хувь болж, өмнөх сараас 0.03 нэгж хувиар өслөө.
- Банкнүүдэн шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 1 дүгээр сард 11.5 хувь болж, өмнөх сараас 0.4 нэгж хувиар буурлаа.



Эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр хөдөлмөрийн зах зээл идэвхжиж 2024 оны 4 дүгээр улиралд ажилчдын тоо 1 сая 353 мянга, ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувьд хүрлээ.



- Ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 31 мянга буюу 2 хувиар нэмэгдэж 1 сая 353 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 165 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- 2024 оны 4 дүгээр улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 21.8 мянгаар, эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 9.4 мянгаар тус тус өссөн байна.




- Ажилчдын тооны өсөлтөд үйлчилгээ ба бусад, худалдаа, барилгын салбарын ажилчид нэмэгдсэн нь эергээр нөлөөлсөн байна.
- Харин хөдөө аж ахуйн салбарын ажилчид, мөн боловсруулах, уул уурхайн салбарын ажилчдын тоо буурсан нь сөргөөр нөлөөллөө.

- Ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар, цар тахлын өмнөх үеэс 1.5 нэгж хувиар өслөө.
- Харин ажилгүй иргэдийн тоо 2024 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 22 мянган хүнээр өсөж 75.4 мянгад хүрсэн байна. Ингэснээр ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар өсөж 5.3 хувьд хүрчээ.

- Дундаж цалингийн хэмжээ 2024 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 23 хувиар өсөж, 2 сая 480 мянган төгрөгт хүрлээ.
- Улсын медиа цалин 2024 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 30 хувиар өсөж, 2 сая 24 мянган төгрөг болов. Энэ нь дундаж цалингаас 468 мянган төгрөгөөр бага байна.
- Салбараар авч үзвэл уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж улсын дунджаас 2.1 дахин өндөр байна.



Өрхийн бодит орлого сүүлийн 7 улирал дараалан өссөн ч өсөлтийн хурд саарлаа.



- Өрхийн бодит орлогын өсөлт 5.9 хувиар болж, өсөлтийн хурд суурийн нөлөөгөөр саарлаа.
- Бодит орлогын өсөлтөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс 233 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 76 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

- Өрхийн дундаж бодит орлогод эзлэх цалингийн орлогын хэмжээ 57.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.3 нэгж хувиар нэмэгдсэн байна.
- Үүнд дундаж цалингийн өсөлтөөс гадна хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн нь нөлөөлж байна.

- Бага орлоготой өрхийн орлого төдийлөн өсөхгүй байна.
- Нийт өрхийн 43.7 хувийг бүрдүүлж буй 1.6 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого оны үнээр 981 мянган төгрөг байна.
- Харин 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого 3,207 мянган төгрөг байна.


- Нийслэлийн өрхийн дундаж орлого 3.1 сая төгрөгт хүрсэн бол хөдөө орон нутгийн өрхийн орлого бага байна.
- Нийслэлийн өрхийн орлогын 65.4 хувийг цалингийн орлого бүрдүүлж байгаа бол хөдөөгийн өрхийн орлогын 15.2 хувийг цалингийн орлого, 37 хувийг хөдөө аж ахуйн орлого бүрдүүлж байна.



Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2024 оны эцэст 261.2 мянгад хүрч өмнөх оны эцсээс 24.7 мянгаар буюу 10.4 хувиар нэмэгдлээ.

### НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО

(мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)




### ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

(ААН-ийн тоо, салбараар)




### ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО

(мянга, ажиллагчдын тоогоор)



### ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС

(улирлаар, 2018=100)



- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2024 оны эцэст 261.2 мянгад хүрч өмнөх оны эцсээс 24.7 мянгаар буюу 10.4 хувиар нэмэгдлээ.
- Уг өсөлтийн 19.2 мянгыг үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан ААН-үүд бүрдүүлсэн бол 6.8 мянгыг үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бүрдүүлээ.
- Үйл ажиллагаа явуулж буй болон шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдэж байгаа нь бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж байгааг илтгэж байна.

- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН 3.8 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 43 хувиар өссөн байна.

- Үйл ажиллагаа явуулж буй 108.4 мянган ААН-ийн 93.5 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай ААН-үүд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн өсөлтийн 91 хувийг бүрдүүлж байна.


- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2024 оны 4 дүгээр улиралд 104.7-д хүрч өмнөх оны мөн үеэс 16.7 нэгжээр сайжирлаа.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 32.9 нэгж, эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 11.5 нэгжээр тус тус нэмэгдсэн байна.
- Үүнд, хэрэглэгчид ажлын олдоц болон бизнесийн нөхцөлийг одоо болон ирээдүйд сайнаар үнэлсэн нь голчлон нөлөөлжээ.



ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 3.1 хувь байна. Төв банкнаас бодлогын хүүг 2024 оны 10 дугаар сард 2 нэгж хувиар өсгөж, 21 хувьд хүргэв. Харин инфляцын түвшин 2025 оны 1 дүгээр сард 9.9 хувьд хүрч, өмнөх сараас 0.4 нэгж хувиар өслөө.

### БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ


(хувь)



- ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 4 дүгээр улиралд 3.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар доогуур байна.
- Цэрэг, армийн зардлын өсөлттэй холбоотой төсвийн зардал тэлэлтээс үүдэн идэвхжээд байсан эдийн засгийн өсөлт ийнхүү саарч байна.

### ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ


(хувь тухайн сард)



- 2024 оны 12 дугаар сарын байдлаар экспорт 417 тэрбум ам.доллар, импорт 294 тэрбум ам.долларт хүрч худалдааны тэнцэл 124 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2024 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 19.2 хувиар буурлаа.
- Импорт 2024 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар буурлаа.

### ИНФЛЯЦ


(хувь)



- Инфляцын түвшин 2025 оны 1 дүгээр сард 9.9 хувь болж, өмнөх сараас 0.4 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 2.5 нэг хувиар тус тус өссөн байна.
- ОХУ-ын инфляц зорилтот түвшин 4 хувиас өндөр хэвээр байна.
- ОХУ-ын Төв банкнаас 10 дугаар сарын 25-ны өдөр бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 21 хувьд хүргэх шийдвэр гаргасан.

### ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)

(нэгж, хувь)




- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2025 оны 1 дүгээр сард 53.1 болж, өмнөх сараас 2.3 нэгжээр өслөө.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2024 оны 12 дугаар сарын байдлаар 8.2 хувь болж, өмнөх сараас 4.7 нэгж өслөө.



БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 онд 5.0 хувьд буюу зорилтот түвшинд хүрлээ. Хэрэглээний үнийн индексийн өсөлт 2025 оны 1 дүгээр сард сүүлийн 5 сарын дээд түвшинд хүрсэн бол үйлдвэрлэгчийн үнэ бууралттай хэвээр байна.


### ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(хувь)




### АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ

(хувь)




### ИНФЛЯЦ

(хувь)



### ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)



- БНХАУ-ын эдийн засаг 2024 онд 5.0 хувиар өслөө. Нийт 31 муж, өөртөө засах орноос 22 нь 5.0 хувиас дээш өсөлт үзүүлсэн байна.
- Экспортын өсөлт 2024 оны 12 дугаар сард 10.7 хувьд хүрснээр 2024 оны нийт экспорт \$3.58 их наяд болж, өмнөх оноос 5.9 хувиар өслөө.
- Импортын өсөлт 2024 оны 12 дугаар сард 1.0 хувьд хүрснээр 2024 оны нийт импорт \$2.59 их наяд болж, өмнөх оноос 1.1 хувиар өслөө.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик. 3 дугаар сард нэлтгэгдэн зарлагдана.

- Аж үйлдвэрийн гарцын өсөлт 2024 оны 12 дугаар сард 6.2 хувьд хүрч эрчимжсэнээр 2024 оны жилийн өсөлт 5.8 хувьд хүрлээ.
- Жижиглэн худалдааны өсөлт 2024 оны 12 дугаар сард 3.7 хувьд хүрч эрчимжсэнээр 2024 оны жилийн өсөлт 3.5 хувьд хүрлээ.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик. 3 дугаар сард нэлтгэгдэн зарлагдана.

- Хэрэглээний үнийн индексийн өсөлт 2025 оны 1 дүгээр сард сүүлийн 5 сарын дээд түвшин болох 0.5 хувьд хүрлээ.
- Харин үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2025 оны 1 дүгээр сард -2.3 хувь буюу өмнөх сарын түвшинд хадгалагдлаа.

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2025 оны 1 дүгээр сард 49.1 болж, агшилтыг илтгэх босго утга 50-аас бага түвшинд эргэн очлоо.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас буурсан ч босго утга 50-аас өндөр хэвээр хадгалагдав.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхийллийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц, эсрэг үзүүлэлтийг туслах аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ